



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/217-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Утас: 703333019 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.6.1 Төсвийн төлөвлөлт	11
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	12
3.6.3 Нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААН	Аж ахуй нэгж
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
НДС	Нийгмийн даатгалын сан
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ҮОМШӨД	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.03.30 № 179
танай _____-ны № _____-т

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГА А.АРИУНТУЯА ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Архангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,117,151.4	8,177,443.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,801,218.6	6,066,661.0
33	АВЛАГА	2,312,507.8	2,108,295.1
35	БАРАА МАТЕРИАЛ	3,425.0	2,487.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	779,411.8	758,247.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	779,411.8	758,247.6
39200	Биет хөрөнгө	764,231.8	743,067.6
39300	Биет бус хөрөнгө	15,180.0	15,180.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,896,563.3	8,935,690.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	252,726.1	218,946.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	252,726.1	218,946.4
41300	Өглөг	33,217.7	23,973.4
41400	Урьдчилж орсон орлого	219,508.4	194,973.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,643,837.2	8,716,744.4
51	Засгийн газрын хувь оролцоо	9,643,837.2	8,716,744.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	224,570.9	224,570.9
51200	Хуримтлагдсан үр дүн	9,418,652.2	8,491,559.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	614.2	614.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,896,563.3	8,935,690.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	77,718,012.2	76,988,634.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	26,643,653.5	28,787,246.8
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	26,643,653.5	28,787,246.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	132,327.9	1,546,061.5
120	Нийтлэг татварын бус орлого	132,327.9	1,546,061.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	50,942,030.8	46,655,326.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	70,719,179.3	77,914,949.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	70,719,179.3	77,914,949.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	730,270.1	724,222.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	504,688.5	504,329.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,221.4	65,625.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,814.0	30,322.3
2104	Хангамж, бараа материалын зардал	33,144.0	24,688.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,710.7	19,500.0
2107	Томилолт, зочны зардал	4,184.0	3,749.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,085.7	32,171.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,421.8	43,836.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,988,909.2	77,190,726.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	6,998,832.9	-926,314.9

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	6,998,832.9	-926,314.9
----	---	-------------	------------

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон / мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,633,955.2	2,633,955.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	11,049.0	11,049.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,645,004.2	2,645,004.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	6,998,832.9	6,998,832.9
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,643,837.2	9,643,837.2
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,643,837.2	9,643,837.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-777.8	-777.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,643,059.4	9,643,059.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	-926,314.9	-926,314.9
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,716,744.4	8,716,744.4

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон / мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	75,600,759.7	77,179,882.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	24,581,575.7	28,229,812.2
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	24,581,575.7	28,229,812.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	191,200.6	589,948.6
120	Нийтлэг татварын бус орлого	191,200.6	589,948.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	50,827,983.4	48,360,121.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	70,688,156.4	77,914,440.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	70,688,156.4	77,914,440.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	681,853.1	678,795.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	504,688.5	504,329.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,221.4	65,625.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,814.0	30,322.3

2104	Хангамж, бараа материалын зардал	30,286.1	24,182.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,710.7	19,500.0
2107	Томилолт, зочны зардал	4,184.0	3,749.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,827.8	29,086.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,120.7	2,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,006,303.3	77,235,645.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,912,603.2	-734,557.6
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	4,912,603.2	-734,557.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,888,615.4	6,801,218.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,801,218.6	6,066,661.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	71,431,173.1	70,215,125.2	1,216,047.9	98.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	71,431,173.1	70,215,125.2	1,216,047.9	98.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	683,230.1	678,430.2	4,799.9	99.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	504,808.2	504,329.0	479.2	99.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,625.1	65,625.1	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,650.0	30,322.3	327.7	98.9
2104	Хангамж, бараа материалын зардал	23,952.1	23,927.8	24.3	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,500.0	19,500.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	3,750.0	3,749.4	0.6	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,944.7	28,976.5	3,968.2	88.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000.0	2,000.0	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,747,943.0	69,536,694.9	1,211,248.1	98.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,747,943.0	69,536,694.9	1,211,248.1	98.3
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	71,431,173.1	26,691,455.4	44,739,717.7	37.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,265,339.8	1,711,346.5	8,553,993.3	16.7
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	61,165,833.3	24,436,138.0	36,729,695.3	40.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	543,971.0	(543,971.0)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,801,218.6	(6,801,218.6)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	6,066,661.0	(6,066,661.0)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	44	44	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	285.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	285.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	285.0
2104	Хангамж, бараа материалын зардал	255.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	285.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	285.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Алтантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 01-ний өдрийн 01/60 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах, нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах, улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх чиг үүрэг бүхий НДЕГ-ын харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ”* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль
- Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай
- Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь НДЕГ-ын даргын тушаалаар 2009 онд батлагдан мөрдөгдөж байгаа бөгөөд хууль журмын өөрчлөлт болон шинэ цахим бүртгэл хөтлөлт нэвтэрч байгаатай холбоотой өөрчлөлт хийгдэж байна.

Тайлант онд НДЕГ-аас аймгийн НДСан болон НДХ-ийн 2015-2021 оны санхүүгийн үйл ажиллагааг хамруулан шалгалт хийгдсэн байна. Шалгалтаар тэтгэвэр тогтоолт, олголттой холбоотой 1,506.0 сая төгрөгийн зөрчил илэрсэнд холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Тус хэлтсийн дотоод хяналт аудитын тасаг нь 2021 онд НДШ-ийн орлого төвлөрүүлэлт болон тэтгэврийн даатгалын сан, тэтгэмжийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт шалгалтуудыг хийжээ. Шалгалтаар шимтгэлийн орлого төвлөрүүлэлттэй холбоотой 10.6 сая төгрөгийн, тэтгэвэр олголттой холбоотой 24.2 сая төгрөгийн, тэтгэмж олголттой холбоотой 12.5 сая төгрөгийн нийт 47.3 сая төгрөгийн төлбөр зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож зөрчлийг арилгуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн НДСан нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүн 55,816.3 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 279.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 209.3 сая төгрөгөөр тогтоосон.

Харин гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүн 76,988.6 сая төгрөгөөс 0.5 хувиар тооцож, материаллаг байдлыг 384.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоон, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын 75 хувь буюу 288.7 сая төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

НДСангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 960.8 сая төгрөгөөр буюу 9.7 хувиар буурч материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	хувь
Б	1	2	3=2-1	4
Мөнгөн хөрөнгө	6,801.2	6,066.7	(734.5)	-10.8
Авлага	2,312.5	2,108.3	(204.2)	-8.8
Бараа материал	3.4	2.5	(0.9)	-26.5
Үндсэн хөрөнгө	779.4	758.2	(21.2)	-2.7
Нийт хөрөнгө	9,896.5	8,935.7	(960.8)	-9.7
Өр төлбөр	252.7	218.9	(33.8)	-13.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,643.8	8,716.7	(927.1)	-9.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгөө өмчийн дүн	9,896.5	8,935.6	(960.9)	-9.7

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 10.8 хувиар буурсан байна.

Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 6,066.0 сая төгрөг нь НДСангийн харилцах дансанд, 0.6 сая төгрөг нь байгууллагын харилцах дансанд байна.

Хүснэгт 2 :Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн бүтэц

сая төгрөгөөр

Ангилал	Сангийн төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:	
				Арилжааны банк	Төрийн сан
Нийгмийн даатгалын сан	Төвлөрсөн орлогын данс	6.2	3.8	3.7	0.1
	Тэтгэврийн даатгалын сан	6,666.0	5,928.9	5,928.9	
	Тэтгэмжийн даатгалын сан	71.6	71.4	71.4	
	ҮОМШӨ-ний даатгалын сан	15.9	18.0	18.0	
	ЭМД-ын сан	1.6	8.5	8.5	
	Ажилгүйдлийн даатгалын сан	39.3	35.5	35.5	
	Нийт	6,800.6	6,066.0	6,065.9	0.1
Байгууллагын үйл ажиллагаа	Үнэт, цаас маягтын данс	0.1	0.1	0.1	
	Ахмадын сан	0.6	0.6		0.6
	Нийт	0.7	0.6	0.1	0.6
Нэгдсэн	Нийт мөнгөн хөрөнгийн дүн	6,801.2	6,066.7	6,066.0	0.7

Сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь арилжааны 4 банкинд байршиж байгаа бөгөөд нийт үлдэгдлийн 68.7 хувь нь ХААН банкинд, 29.9 хувь нь Төрийн банкинд, 1.4 хувь бусад банкинд тус тус байна.

- Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 8.8 хувиар буурсан байна.

Нийт авлагын үлдэгдлийн хувь 4.1 хувь буюу 83.6 сая төгрөг нь төлбөртэй үйлчилгээний авлага /НДШ-ийн авлага/, 47.7 хувь буюу 969.0 сая төгрөг нь татаас санхүүжилтийн авлага, 48.2 хувь буюу 978.9 сая төгрөгийн бусад авлага байна.

Хүснэгт 3: Авлагын үлдэгдлийн бүтэц

сая төгрөгөөр

Төрөл	Авлагын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Тайлбар
Нийгмийн даатгалын сан	Төлбөртэй үйлчилгээний авлага	13.5	35.7	Төсөвт байгууллагын шимтгэлийн авлага
		29.8	47.9	ААНБ-ын шимтгэлийн авлага
	Нийт	43.3	83.6	
	Татаас санхүүжилтийн авлага	2,254.9	1,045.8	НДШ-ийн чөлөөлөлт, ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон дэмжлэгийн санхүүжилтийн авлага
	Бусад авлага	14.3	978.9	Тэтгэврийн даатгалын санд тавигдсан улсын байцаагчийн акт, тэтгэмжийн илүү олголт, сан хооронд ташаарсан авлагууд
	Нийт авлагын дүн	2,312.5	2,108.3	

Татаас санхүүжилтийн авлага өмнөх оноос буурсан байна. Өмнөх онд ковид цар тахалтай холбоотой ААН-ийг дэмжих зорилгоор хэрэгжсэн “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль”-ийг хэрэгжүүлсэнтэй холбоотой 2020 онд 2,177.9 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлага үүссэнээс тайлант онд 2,006.4 сая төгрөг нь барагдаж, 2021 оны эхний хагас жил дуустал 797.5 сая төгрөгийн НДШ-ийг чөлөөлж, оны эцэст 969.0 сая төгрөгийн авлага, ажилгүйдлийн даатгалын сангаас 2020 онд олгосон 76.8 сая төгрөгийн авлага нь тайлант онд барагдаагүй нийт 1,045.8 сая төгрөгийг улсын төсвөөс авах татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна. Харин бусад авлага өмнөх оноос өссөн нь НДЕГ, дотоод хяналт аудитын тасгаас хийгдсэн тэтгэврийн даатгалын санд тогтоосон улсын байцаагчийн актын үлдэгдэл 975.9 сая төгрөг, тэтгэмжийн илүү олголт, сангийн ташаарсан 3.0 сая төгрөгийн авлагыг бүртгэсэнтэй холбоотой байна.

- *Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 26.5 хувиар буурсан байна.*

Бараа материалын данс нь 3.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 21.2 сая , шилжүүлэн авсан 3.0 сая нийт 24.2 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 24.9 сая, шилжүүлсэн 0.2 сая нийт 25.1 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 2.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- *Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 2.7 хувиар буурсан байна.*

Үндсэн хөрөнгө данс нь 779.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд шилжүүлэн авсан 50.8 сая, бусад 17.1 сая төгрөг нийт 67.9 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 89.1 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч, 758.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- *Өр төлбөрийн үлдэгдэл 13.4 сая төгрөгөөр буурсан байна.*

Нийт өр төлбөрийн үлдэгдэлийн 89.1 хувь буюу 195.0 сая төгрөг нь урьдчилж төлөгдсөн шимтгэлийн орлого, 10.9 хувь буюу 22.8 сая төгрөг нь бусад өглөг байна.

Хүснэгт 4: Өр төлбөрийн үлдэгдлийн бүтэц

сая төгрөгөөр

Төрөл	Өр төлбөрийн төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Тайлбар
Нийгмийн даатгалын сан	Урьд төлөгдсөн шимтгэлийн орлого	47.9	33.2	Төсөвт байгууллага, ААН-ийн шимтгэлийн урьдчилсан төлөлт
		171.6	161.8	Сайн дурын даатгуулагч болон бусад шимтгэлийн урьдчилсан төлөлт
	Нийт	219.5	195.0	
	Тэтгэвэр, тэтгэмжийн өглөг	0.7	1.1	Тайлант хугацаанд олгогдоогүй тэтгэмж
	Бусад өглөг	32.5	22.8	Нөхөн даатгалд хамрагдсан анхан шатны баримтын бүрдэл хангагдаагүй даатгуулагчийн төлсөн шимтгэлүүд, сан ташаарсан орлого
	Нийт авлагын дүн	252.7	218.9	

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн хэрэгжилт 2021 оны 7 дугаар сарын 01-нээс, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн хугацаа тайлант онд дууссан байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүнг 926.3 сая төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн, НББ-ийн өөрчлөлт дансанд 0.8 сая төгрөгийн бичилт хийгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 5. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

сая төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
НДШ-ийн орлого	26,643.7	28,787.2	2,143.5
Татварын бус орлого	132.3	1,546.1	1,413.8
Тусламж, санхүүжилтийн орлого	50,942.0	46,655.3	(4,286.7)
Үйл ажиллагааны орлого	77,718.0	76,988.6	(729.4)
Цалин, шимтгэлийн зардал	567.9	569.9	2.0
Бусад бараа үйлчилгээний зардал	70.9	78.3	7.4
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50.1	32.2	(17.9)
Бараа үйлчилгээний бусад зардал	41.4	43.8	2.4
Урсгал шилжүүлэг	69,988.9	77,190.7	7,201.8
Үйл ажиллагааны зардал	70,719.2	77,914.9	7,195.7
Үйл ажиллагааны үр дүн	6,998.8	(926.3)	(7,925.1)

НДШ-ийн орлого өмнөх оноос 2,143.5 сая төгрөг буюу 8 хувиар өссөн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Харин тусламж санхүүжилтийн орлого өмнөх оноос 4,286.7 сая төгрөгөөр буюу 8.4 хувиар буурсан дүнтэй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

НДСангийн орлогын төлөвлөлт

Нийгмийн даатгалын сангийн орлогыг 18,516.9 сая төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн боловч төслийг 1,180.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 19,697.4 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Харин төсвийн тодотголоор анх баталсан төсвийг 426.1 сая төгрөгөөр бууруулж 19,271.3 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

НДСангийн зардлын төлөвлөлт

НДСангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 65,238.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг анх 6,626.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 71,865.4 сая төгрөгөөр хянаж баталсан бол төсвийн тодотголоор 434.2 сая төгрөгөөр бууруулж 71,431.2 сая төгрөг болгож баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

НДСангийн нийт орлогын гүйцэтгэл 26,691.4 сая төгрөг буюу 138.5 хувьтай, төсвийн зарлагын гүйцэтгэл 70,215.2 сая төгрөг буюу 98.3 хувьтай байна. НДСангийн орлого, зарлагын төлөвлөгөө гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 6. Орлого, зарлагын төлөвлөгөө гүйцэтгэл сая төгрөгөөр

/СТГТ-6-тайлангаас чөлөөлөлт хассан дүн/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Санхүүгийн нэгтгэсэн ТГТ-ийн нийт орлого	19,271.3	26,691.4	(7,420.1)	138.5
Сангийн нийт зардал	70,721.7	69,510.3	1,211.4	98.3
Үйл ажиллагааны нийт зардал	709.5	704.9	4.6	99.4
Санхүүгийн нэгтгэсэн ТГТ-ийн нийт зардлын дүн	71,431.2	70,215.2	1,216.0	98.3

НДСангийн орлогын гүйцэтгэлийн талаар

Тайлант онд НДСан нь 19,271.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 26,691.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 138.5 хувиар биелүүлсэн байна.

Сан тус бүрээр орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 7. Сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл сая төгрөгөөр

Сангийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэвэр	16,889.0	23,931.6	(7,042.6)	141.7
Тэтгэмж	1,385.0	1,571.3	(186.3)	113.5
ҮОМШӨ	714.3	866.2	(151.9)	121.3
Ажилгүйдэл	283.0	322.3	(39.3)	113.9
Дүн	19,271.3	26,691.4	(7,420.1)	138.5

Сан тус бүрээр орлогын төлөвлөгөөг 113.5-141.7 хувиар биелүүлсэн байна.

НДХ-ийн үйл ажиллагаа болон НДСангийн зарлагын гүйцэтгэлийн талаар

НДСангийн зардлын талаар:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 70,721.7 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 69,510.3 сая төгрөгийг зарцуулж, НДСангийн зардлын гүйцэтгэл 98.3 хувьтай байна.

Сангийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сан тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна

Хүснэгт 8. Сан тус бүрийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл сая төгрөгөөр

/ СТГТ-6-тайлангаас хэлтсийн ү/а-ны зардал, чөлөөлөлт хассан дүн/

ДД	Сан	Төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Тэтгэврийн даатгалын сан	Өндөр насны тэтгэвэр	54,124.2	54,678.6	(554.3)	101.0
		Тахир дутуугийн тэтгэвэр	9,139.8	8,064.2	1,075.6	88.2
		Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	3,044.5	2,625.6	418.9	86.2
		Цэргийн албан хаагчийн тэтгэвэр	1,326.2	1,188.5	137.6	89.6
		Тэтгэвэр авагчийн банкны үйлчилгээний хөлс	8.0	7.9	0.1	98.3
		Бусад зарлага	2.6	8.9	(6.3)	343.1
		Тэтгэврийн сангийн зарлагын дүн	67,645.4	66,573.6	1,071.7	98.4
2	Тэтгэмжийн даатгалын сан	ХЧТАлдсаны тэтгэмж	100.6	120.6	(20.0)	119.9
		Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	1,647.9	1,629.3	18.6	98.9
		Оршуулгын тэтгэмж	443.0	441.0	2.0	99.5
		Эхийн хүүхдээ асрах чөлөөний хугацааны тэтгэмж	198.9	63.7	135.2	32.0
		Бусад зарлага	0.2	0.4	(0.2)	211.9
		Тэтгэмжийн сангийн зарлагын дүн	2,390.6	2,255.0	135.5	94.3
3	ҮОМШӨ-ний даатгалын сан	Тахир дутуугийн тэтгэвэр	100.5	101.7	(1.3)	101.3
		Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	30.3	29.1	1.1	96.3
		ХЧТАлдсаны тэтгэмж	6.3	6.9	(0.5)	108.5
		Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээх зардал	1.0	1.8	(0.8)	175.0
		Рашаан сувилалын зардал	1.3	-	1.3	-
		Тэтгэврийн даатгалын санд шилжүүлсэн шилжүүлэг	9.1	8.3	0.8	91.6
		Тэтгэвэр олголын банкны үйлчилгээний хөлс	0.0	0.0	0.0	40.2
		Бусад зарлага	-	0.3	(0.3)	-
		ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлагын дүн	148.4	148.1	0.3	99.8
4	Ажилгүйдлийн даатгалын сан	Ажилгүйдлийн тэтгэмж	537.2	533.5	3.7	99.3
		Бусад зарлага	0.2	0.0	0.2	1.5
		Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлагын дүн	537.3	533.5	3.9	99.3
Сангийн нийт зарлагын дүн			70,721.7	69,510.3	1,211.4	98.3

Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын санд 44,650.2 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын санд 1,034.9 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын санд 253.8 сая төгрөг нийтдээ улсын төсвөөс 45,939.0 сая төгрөгийн татаас авч, тэтгэврийн даатгалын сангаас 2,750.0 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 335.2 сая төгрөг, ҮОМШӨД-ын сангаас 714.2 сая төгрөг, ЭМДС-аас 3,784.7 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 73.3 сая төгрөг нийтдээ 7,657,4 сая төгрөгийг төв санд буцаан төвлөрүүлсэн байна.

НДХ-ийн үйл ажиллагааны зардлын талаар:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 709.5 сая төгрөг батласныг НДСангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр НДСангаас 709.5 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, 704.9 сая төгрөгийг зарцуулж, үндсэн үйл ажиллагааны санхүүжилтээс 4.6 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 0.8 сая, нийт 5.4 сая төгрөгийг НДЕГ-т буцаан төвлөрүүлсэн байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр НДЕГ-аас сургалтанд зориулж 0.3 сая төгрөг олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

НДЕГ-аас 2021 оны 9 дүгээр сард батлагдсан удирдамжийн дагуу аймгийн НДС-ийн 2017-2020 он, 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагааг хамруулан хяналт шалгалтыг хийжээ. Шалгалтын дүнд тэтгэвэр тогтоолт, олголттой холбоотой 1,506.0 сая төгрөгийн зөрчил төлбөр илэрсэнд НДХ-ийн дотоод хяналт шалгалтын тасгийн улсын байцаагч нар хариуцан холбогдох арга хэмжээг авч ажиллаж байгаа бөгөөд зарим зөрчилтэй асуудлыг аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн байгууллагад шилжүүлэн шалгуулж байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг Аймгийн Засаг даргаас 91.6 хувь гэж үнэлсэн бөгөөд НДЕГ-аас үнэлгээний нэгдсэн дүнг ирүүлээгүй байна.

Тайлант онд шимтгэлийн орлогоор 19,271.3 сая төгрөгийг төвлөрүүлэхэр батлагдаж, гүйцэтгэлээр 26,691.4 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 138.5 хувиар давуулан биелүүлсэн бол хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 71,431.2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 70,215.2 сая төгрөгийг зарцуулж, 98.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаарх судалгааг авч үзэхэд:
 - Батлагдсан төсөвт зардлаас 4.6 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож, НДЕГ-т төвлөрүүлсэн байна.
 - Өндөр-Улаан сумын нийгмийн даатгалын байцаагч нь өндөр насны тэтгэвэр тогтоолгон чөлөөлөгдсөнд нөхөх томилгоо хийж, 7.9 сая төгрөгийн цалин олгосон байна.
 - Сургалт семинар зохион байгуулахтай холбоотойгоор дотоод албан томилолтын зардлаас 1.9 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 2.0 сая төгрөгийг зарцуулсан байна.
 - Бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
2. Суудлын автомашин ашиглалтын судалгааг авч үзэхэд тус байгууллага нь нийт 22.8 сая төгрөгийн анхны өртөг бүхий 2 автомашинтай, шатахууны зардалд 8.8 сая сэлбэг засварын зардалд 13.2 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд жолоочийн цалинд 6.5 сая төгрөгийг олгосон байна.
3. Хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж, гэрээний төлбөрт 0.3 сая төгрөгийг зарцуулжээ.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж, үр дүнг баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

НДХ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 150, НДС-ийн 161 мэдээллийг 100 хувь хугацаанд нь байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

- Тус байгууллага нь 2021 оны 10 дугаар сард нийгмийн даатгалын 19 сумын байцаагч нарыг оролцуулан нэгдсэн сургалт зөвлөгөөнийг зохион байгуулж, дотоод албан томилолтын зардлаас 1.9 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 2.0 сая нийт 3.9 сая төгрөгийг зарцуулсан нь Монгол Улсын ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.5-т “Салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал зөвлөгөөн болон газар дээрх хяналт шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар ,хурал зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

- Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгийн оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 5.8 % буюу 6.6 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Хайрхан суманд байрлалтай нийгмийн даатгалын тасгийн 2 давхар 5 өрөө бүхий 252 м.кв барилгын 2 өрөө нь ашиглагдаж, бусад өрөөнүүд нь ашиглалтгүй, төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулж байгаа зөрчил илэрсэнд төсвийн хөрөнгийн үр ашигт байдлыг дээшлүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах талаар зөвлөмж хүргүүлсэн бөгөөд тайлант түрээсийн орлогоор 3.3 сая төгрөгийг НДЕГ-т төвлөрүүлж, 1 иргэнтэй гэрээ байгуулан түрээслүүлэхээр шийдвэрлэсэн боловч ковид цар тахалтай холбоотой хөл хорио тогтоосны улмаас гэрээ байгуулаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Няравын анхан шатны баримтын бүрдүүлэлт, тайлан, тооцоог нарийвчлан авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зөрчил илрээгүй болно.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	НДС	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	НДС	2	10.5	0	0	0	0	2	10.5	0	0
	Дүн	2	10.5	0	0	0	0	2	10.5	0	0
	Нийт дүн	2	10.5	0	0	0	0	2	10.5	0	0